



СЭЛЭНГЭ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2020 оны 06 сарын 03 өдөр

Дугаар А/157

Сүхбаатар сум

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.3-ын "г", Засгийн газрын 2016 оны "Журам шинэчлэн баталж, тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай" 10 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт Газар өмчлүүлэх, эзэмшүүлэх, ашиглуулах дуудлага худалдаа явуулах журмын 9.1, аймгийн Засаг даргын 2011 оны "Аймгийн төвийн инженерийн шугам сүлжээ бүхий бүсийн хилийг шинэчлэн тогтоох тухай" А/39, 2020 оны "Газар эзэмшүүлэх цахим дуудлага худалдаа явуулах тухай" А/113 тоо захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн төвийн инженерийн шугам сүлжээ бүхий газруудад газар эзэмшүүлэх цахим дуудлага худалдаа явуулах үүрэг бүхий ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай. Үүнд:

Ажлын хэсгийн дарга:

Б.Саруултөгс

-Газрын харилцаа, барилга,
хот байгуулалтын газрын дарга

Дуудлага худалдааны хөтлөгч:

Б.Мөнхсоёл

-Газрын харилцаа, барилга, хот
байгуулалтын газрын Газрын
удирдлагын хэлтсийн дарга


Тэмдэглэл хөтлөгч:

Б.Маралцэц

- Газрын харилцаа, барилга, хот
байгуулалтын газрын Газрын суурь
судалгаа мониторинг хариуцсан
мэргэжилтэн

2. Газар эзэмшүүлэх дуудлага худалдааг зохих журмын дагуу зохион байгуулж, хяналт тавьж ажиллахыг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга /Б.Саруултөгс/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ОРГИЛ

C:\users\albanbichig2020\zahiramjA4.docx

430891744